

## **БАТЛАВ.**

**САНГИЙН САЙД**

**ХУУЛЬ ЗҮЙН САЙД**

**Ч.УЛААН**

**Х.ТЭМҮҮЖИН**

### **МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

#### **Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “Төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг;” гэж, 4.1.6-д “Улсын төсөв” гэж Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар болон улсын төсөвт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;” гэж, 8 дугаар зүйлийн 8.4.4-д санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт өргөн мэдүүлэх;” гэж, 8.4.5-д “Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх,” мөн зүйлийн 8.4.8-д “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах.” гэж тус тус заасан нь Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль эрх зүйн үндэслэл болж байна.

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан төсвийн жилд Төсвийн алдагдалыг санхүүжүүлэх эх үүсвэр, Засгийн газрын шинээр үүсэх өр, гаргах баталгааны дээд хязгаар, төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлт, улсын төсвийн байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны санхүүжилт, цалин, тэтгэвэр, тэтгэмж, улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүжүүлэх хэмжээ, хязгаар зэргийг тухайн жилийн төсвийн хуулиар тогтоон батлуулах зайлшгүй шаардлагатай.

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан “Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох” тусгай шаардлагыг баримтлан, уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлогыг төлөвлөхдөө төсвийн орлогод ихээхэн нөлөө үзүүлдэг гол нэр төрлийн эрдэс

баялгийн үнийг олон жилийн дундаж үнэ болох тэнцвэржүүлсэн үнээр тооцож, тэнцвэржүүлсэн үнээс давсан хэсгийг Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх болон төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөр арга хэмжээг жигд санхүүжүүлэх тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх зарчмыг баримтална.

**Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслөөр Монгол Улсын 2014 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарлагын хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлттэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана.

Төсвийн тухай хуульд заасан төсвийн үндсэн зарчмуудыг баримталж нийгмийн эмзэг бүлгийг хэт ядуурлаас хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, цалин хөлс, төсвийн хөрөнгийг оновчтой, зүй зохистой хуваарилах замаар ажилгүйдэл ядуурлыг бууруулах, хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн баталгааны асуудлыг салбар бүрт өөрөөр тогтоож, тухайн нэг салбарыг онцгойлон нэмэгдүүлдэг явдлыг зогсоож нийтлэг нэг байлгах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгаж татварын бодлогоор дамжуулан орлогын тэгш хуваарилалтыг хангах, Хүүхдийн мөнгө олгогдож эхэлсэнтэй уялдуулан зарим төрлийн халамжийн шинжтэй арга хэмжээний давхардлыг арилгах, хөрөнгийг оновчтой зарцуулах зорилгоор дараах хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг бууруулахаар тусгана.

Хуулийн төсөл 4 бүлэг, 16 зүйлтэй байна.

1. “Нийтлэг үндэслэл” гэсэн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

2. “Монгол Улсын 2014 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө, өрийн удирдлага” гэсэн хоёрдугаар бүлэгт: Монгол Улсын 2014 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын доод хэмжээ, зарцуулах зарлагын дээд хэмжээг, мөн төсвийн ерөнхийлөн захирагчид, түүний харъяа байгууллагууд, бусад байгууллагуудын төвлөрүүлэх орлогын хэмжээг, 2014 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсөв, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын хэмжээ, төсвийн тогтворжуулалтын санд 2014 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, Засгийн газрын шинээр гаргах баталгааны дээд хязгаарын талаар;

3. “Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг” гэсэн гуравдугаар бүлэгт орон нутгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлогын хэмжээ, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг;

4. “Бусад зүйл” гэсэн дөрөвдүгээр бүлэгт төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2014 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар батлах тухай, улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг хавсралтаар батлах тухай;

5. Хуулийн төслийн 16 дугаар зүйлд тус хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

### **Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар 2014 оны төсвийн жилд Засгийн газраас чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр бий болж, 2014 оны Засгийн газрын мэдэлд мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хуваарилж, зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Монгол Улсын төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд төсөв, татварын орлогыг тогтвортой байлгах, төсвийн санхүүжилтийг найдвартай эх үүсвэрээр хангахын тулд 2014 оны төсвийн төсөлд улсын төсвийн орлогыг бодитой төлөвлөх, төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлах, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг бий болгох, татвар хураалтыг эрчимжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

### **Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2013 оны 41 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.